


生コンクリート製造業の安全衛生

Комикоор мэдэх

Бетон зуурмаг үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуй



Энэхүү дуу дүрст сургалтын материал нь бетон зуурмагийн үйлдвэрлэлийн ажлын талбайд ажилладаг та бүхэнд зориулсан аюулгүй байдал болон эрүүл ахуйн үндсэн мэдлэг олгоход зориулан боловсруулсан материал болно.




Өнөөдөр бетон зуурмаг үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар суралцацгаая!




Барилга, гүүр, далан зэргийн барилгын ажилд зайлшгүй шаардлагатай материал хийх чухал ажил шүү.

Тийм шүү!

Бетон зуурмаг нь бидний амьдрал, нийгмийг бүтээхэд чухал шүү.




Бас гамшгаас бидний амьдралыг хамгаалдаг.



Ийм ажлын талбарт ч гэсэн үйлдвэрлэлийн осол үүсдэг юм шүү.

Хөөх ~!


Тэгэхээр үйлдвэрлэлийн ослын гол шалтгааныг авч үзье.



Үйлдвэрлэлийн ослын улмаас хохирсон хүмүүсийн байдал

1	Миксерээс унах, онхолдох	55%
2	Туузан дамнуургад хавчуулагдах, ороогдох	21%
3	Бусад тоног төхөөрөмжид хавчуулагдах, ороогдох	14%
4	Силосын дотор дарагдах	6%
5	Таварцаглаж унах	4%

Үндэсний Бетон Зуурмаг Үйлдвэрлэгчдийн Нэгдсэн Холбоо (2014-2020 он)



Ялангуяа "Миксерээс унах, онхолдох", "Туузан дамнуургад хавчуулагдах, ороогдох" нь их тохиолддог байх нээ...



Дараа нь
"Туузан дамнуургад хавчуулагдах, ороогдох".
Үзлэгийн явцад, туузан дамнуурга ажиллаж
байхад нь хавчуулагдсан гадны биетийг авах
гэж байгаад ажилчны гар керентэй
ороогдсон гэх осол гарч байсан.



[Кэрэн]

Хатуурсан бохирдлыг
унагах зориулалттай төмөр
цэвэрлэгээний багаж.

Туузан дамнуургыг ажиллуулахад их хүч
ашигладаг тул, ороогдсон тохиолдолд
том осол болох магадлалтай байдаг юм байна.

Тэжээлийг нь салгахаа мартаад,
туузан дамнуурга нь
гэнэт ажиллаж эхлэх
тохиолдол ч байдаг юм шиг байна.



Санамсар болгоомжгүйгээр
эргэлдэж байгаа биет рүү
ойртох нь маш осолтой юм шүү.



Өөрөөр ч бас материалын
элс байсан силос дотор ажилчин
нас барсан осол гарч байсан
гэж сонсож байсан...



Тийм ээ. Силосын хананд
тогтсон элсийг хусаж унагах
ажлыг хийж байхад овоорсон
элс нурж ажилчин
дарагдсан байсан.



Таварцаглаж унах осол ч
гэсэн байнга гардаг тэ?



Тавцанд
бүдэрч,

гадаргуу нь хөлдсөн зам дээр
хөл нь халтирч таварцаглаж
унах осол ч бас олон байдаг.



Аанхаа....

カフツ...

Тэгэхээр дараа нь,




Бодит барилгын
талбайг,

Харцгаая!



CASE 1





Хүлээж байх хугацаа хайран байна.

Жаахан ч гэсэн ахиулья!



Аааа!



Би ирлээ. ... юу? Хаашаа явчихаа вэ?

... хэн нэгэн ~!



Яанаа!



Яаралтай гаргахгүй бол...!



Аюултай шүү, наанаа хөдөлгөөнгүй бай! Одоохон гаргалаа!

...3аа.



Хэлээд байхад...
Хүчилж огт болохгүй
гэж хэлсэн биз дээ.

Намайг уучлаарай...

Энэ удаад ноцтой зүйл
болсонгүй яамай даа...

Цаашид ажлын байрны дүрэм,
зааврыг ягштал баримтална шүү.
Өөрсдийн шийдвэрээр
дураараа үйлдэл хийхгүй байхад анхаар!



Силос дотор наалдсан
элсийг хусах ажилд
элсний овоолго нурж унаад,

ажилчин
бүтэн биеэрээ дарагдаж,
нас барсан гунигтай
осол ч гарсан шүү.




Ослоос сэргийлэхийн
тулд ч бүгд анхааралтай
ажиллана шүү!

За!


CASE 1
Дүгнэлт

Силос дотор аюулгүй ажиллахын тулд


1 Зарчмын хувьд элс шороо зэрэгт дарагдах эрсдэлтэй газар ажиллахгүй байх.



2 Силос дотор ажиллах үед хянагч байршуулж, ганцаар ажиллахгүй.




3 Силос дотор ажиллах үед тогтоосон хамгаалалтын хэрэгслийг зүүж, аюулгүй ажиллах боломжтой эсэхийг нягталсны дараа хийнэ. Тэр тохиолдолд хянагчийг заавал байлцуулна.



Ялангуяа чийгтэй үед их хэмжээний элсэнд дарагдах юм бол гаргаж авахад хүндрэлтэй болно. Их хэмжээний элсэнд дарагдсан үед уушгинд хүчтэй даралт ирэхийн дээр, цусны урсгал муудаж, амьсгалахад хүндрэлтэй болох зэргээр үхэлд хүргэдэг.

CASE 2






Тэгэхээр ...!

Ээ?



Балар аа!


Баларсан,
яаралтай зогсолт!



Аймаар байлаа...



Тууз яагаад
зогсчихов!




Тэр бол...



... Байдлыг ойлголоо..

Энэ удаад ноцтой зүйлд бололгүй өнгөрсөн нь зол боллоо,



Аюултай том осол болох гэж байсан шүү.

Өнгөрөгч хугацаанд туузан дамнуургад ажлын хувцас татагдах, ороогдож амь насаа алдсан хүн ч байгаа.

Тоног төхөөрөмж болон машин механизмд хүрэх тохиолдолд тэжээлийг заавал салгаж байх ёстой.



Дүрэм бүр өөрийн гэсэн утгатай.

За...!


CASE2
Дүгнэлт

Туузан дамнуурга орчимд аюулгүй ажиллахын тулд

1 Туузан дамнуургад хүрэх үед, узелийн өрөөрүү холбоо барьж, тэжээлийг заавал салгасны дараа гүйцэтгэнэ.




2 Ажиллаж буй машин механизмд яасан ч гар хүрч болохгүй.



3 Ажлын хувцасны ханцуйг сайтар тогтоож, хамгаалах хэрэгслийг дүрмийн дагуу зүүнэ.





4 Ямар нэг тохиолдолд бэлдэж, яаралтай зогсоох төхөөрөмжийн байршил болон ашиглах аргыг тогтоон цээжилж авах.



5 Узелийн өрөөний ажилтан нь барилгын талбайн ажилтан ажлаа дууссан эсэхийг шалгасны дараа тэжээлийг өгнө.



CASE 3





Тэнгэр ч сайхан боллоо,
яаравчлан угаалга цэвэрлэгээ
хийхгүй бол...!



Хийж дадсан ажил ч
юм хамгаалалтын
бүс зүүхгүй байсан
ч яадгийн.



Ингээд
дууслаа.

ちん

V
V
V



Аааа аа!



Яасан бэ!?

Яанаа!

Хэн нэгэн түргэн
тусламж
дуудаад өг!




CASE3
Дүгнэлт

Гишгүүр дээр аюулгүй ажиллахын тулд


- 1** Хамгаалах хэрэгсэл (дуулга, хамгаалалтын бүс, халтирахаас сэргийлсэн гутал) байнга зүүж байх ёстой.




- 2** Хамгаалалтын бүсний дэгээг ашиглан заавал 3 цэгийн тулгууртайгаар авирч бууж байх ёстой.




- 3** Миксерийн арын хэсэг нь өндөр бөгөөд давчуу байдаг тул тэнцвэр алдаж унах зэрэг аюул байдгийг сайтар ухамсарлаж, дүрэм баримтлан ажиллана.





Аюул осол санаанаас гадуур өөрт ойр байдаг зүйл гэдгийг сайн ойлгов уу?



Энд гарсан дүрүүдийн инээдтэй хэсэг нь хэн нэгэнтэй төстэй байлаа.

Харин? Ямар нэг юм хэлсэн үү?



Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд хүн бүрийн ухамсар, дүрэм журмыг дагаж мөрдөх нь чухал.

Энд дахин нэг Кейсийн судалгааг эргэн харцгаая.

Бетон зуурмаг үйлдвэрлэхэд анхааруштай гол санаа




1 | Силос дотор элс хусаж унагах




Силос доторх ажилд заавал хянагч байлцуулахын дээр дүрмийг дагаж мөрдөх ёстой.

2 | Туузан дамнуурга дахь гадны биетийг зайлуулах



Туузан дамнуургад шууд хүрэх тохиолдолд тэжээлийг заавал салгаж, хамаарах этгээдэд ажил хийгдэж байгаа тухай мэдэгдэнэ.

3 | Миксерийн гишгүүрээс унах




Миксерийн гишгүүрээр авирч буухдаа хамгаалалтын бүсний дэгээг ашиглан хоёр гар хоёр хөлөөрөө байнга 3 цэгийн тулгууртайгаар биеэ тулж байх.



Үйлдвэрлэлийн осол бол бусдын хэрэг огт биш бөгөөд өөрт ойр байдаг асуудал юм.

Дүрэм дагаж мөрдөх гэдэг нь "өөрийн бие", "гэр бүл", "амьдрал"-аа хамгаалах явдал гэдгийг цээжилж авах хэрэгтэй.



Ямар нэг зүйл тохиолдсон үед өдөр тутмын ажлын байран дээрх харилцаа ч бас чухал юм.



За тэгэхээр! Үйлдвэрлэлийн ослоос анхаарч болгоомжлон өдөр бүр хичээн ажиллацгаая!


Бетон зуурмагийн үйлдвэрлэл

Эдгээр зүйлүүдэд ч анхааралтай байцгаая! Аюулгүй, эрүүл байх зөвлөмжүүд!



1 | Миксерийн анхаарах зүйлс

1 | Жижиг гишгүүр




Гишгүүр нь жижиг байдаг тул ялангуяа усанд норсон үед халтирахаас болгоомжил.

2 | Хошуунд хавчуулагдах



Хошууг буцаах үед гараа хавчуулахаас сайтар болгоомжлон ажиллана.

3 | Гэнэтийн хөдлөх



Миксерийн арын хэсэгт ажиллах үед жолоочид мэдэгдэн, ослоос сэргийлэн ажиллахыг хичээх.

2 | Явган явахад анхаарах зүйлс



Үйлдвэр дотор дуулга өмсөж, хөл доорх догол болон замын гадаргууг сайтар анхаарч явах.

3 | Лабораторид анхаарах зүйлс




Сорьц болон хүнд багаж хэрэгсэл зэрэг нь хөл дээр унах тохиолдол байдаг тул заавал хамгаалалтын гутал өмсөх.


Ажлын байранд ажиллах явцад нуугдаж буй аюул ослыг мэдэцгээе!

Аюулыг урьдчилан таних сургуулилт (АУТС)

Q Хаана аюултай вэ гэдгийг бодоорой!



A Энэ бол аюулын цэг!



1

Хамгаалалтын бүсний дэгээг ашиглан заавал 3 цэгийн тулгууртай авирч бууна.




2

Таварцаглаж унахгүйн тулд хөл доорх догол болон замын гадаргууг сайтар анхаарна.



3

Ухрахаас хамгаалан миксерийн ард орохгүй.



Өөр аюул ослын цэг байгаа эсэхийг бодоорой.

Комикоор мэдэх

Бетон зуурмаг үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуй

2022 оны 3-р сарын хэвлэл

Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөн хэрэгжүүлсэн: Mizuho Research & Technologies, Ltd.

Хамтран ажилласан: Бетон зуурмаг үйлдвэрлэлийн аюулгүй байдлын

боловсрол сургалтын материал боловсруулах ажлын хэсэг

Хэвлэсэн: Sideranch Inc.



Энэ материалтай холбоотой холбоо барих
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар